



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/153/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2021 он

Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч:
Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020 Цахим хаяг:

Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020 Цахим хаяг:

Kherlenchimegch@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
У.БАЯРБИЛЭГ ТАНАА

дсн.од.10 № 1-6/47
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар аймгийн ОНӨГ-ын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Шуудан холбооны зардлаас 200.0 мянган төгрөгийг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардлаас 4,202.2 мянган төгрөгийг, нийт 4,402.2 мянган

төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байгаа нь санхүүгийн тайлангийн Үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>12,748,543.00</u>	<u>11,325,060.16</u>
33	АВЛАГА	-	93,593.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	93,593.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,748,543.00	11,231,467.16
354	Хангамжийн материал	12,748,543.00	11,231,467.16
35410	Бичиг хэргийн материал	994,700.00	741,400.00
35420	Аж ахуйн материал	11,593,843.00	7,670,067.16
35440	Түлш, шатах тослох материал	160,000.00	2,820,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>93,971,852.50</u>	<u>1,498,824,054.52</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	93,971,852.50	1,498,824,054.52
392	Биет хөрөнгө	86,411,852.50	1,489,537,054.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,010,325.35	1,099,142,643.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(758,962.68)	(28,408,279.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,048,000.00	78,048,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(53,189,165.88)	(63,876,165.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,135,605.00	343,637,729.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,459,021.75)	(59,707,647.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,469,920.00	96,883,940.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,299,440.06)	(13,914,918.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	90,873,220.00	90,873,220.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(47,418,627.48)	(53,141,467.80)
393	Биет бус хөрөнгө	7,560,000.00	9,287,000.00
39301	Програм хангамж	2,750,000.00	2,277,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,750,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,560,000.00	7,560,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>106,720,395.50</u>	<u>1,510,149,114.68</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>93,593.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	93,593.00
413	Өглөг	-	93,593.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	57,593.00
4136	Бусад өглөг	-	36,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	36,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>106,720,395.50</u>	<u>1,510,055,521.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	106,720,395.50	1,510,055,521.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	19,136,525.00	19,136,525.00
51101	Өмч: - төрийн	19,136,525.00	19,136,525.00
512	Хуримтлагдсан үр дүн	87,583,870.50	1,490,918,996.68
51210	Өмнөх үеийн үр дүн	87,583,870.50	87,583,870.50
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,403,335,126.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>106,720,395.50</u>	<u>1,510,149,114.68</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	154,314,700.00	1,680,808,609.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,662,500.00	1,525,346,446.95
120	Нийтлэг татварын бус орлого	11,662,500.00	1,525,346,446.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,662,500.00	1,525,346,446.95
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,662,500.00	8,010,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,517,336,446.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	142,652,200.00	155,462,162.44
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	600,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	142,652,200.00	154,862,162.44
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,652,200.00	154,862,162.44
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	168,763,928.08	248,658,454.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	168,763,928.08	248,658,454.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	161,995,126.73	246,319,158.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,868,099.67	116,331,488.40
210101	Үндсэн цалин	77,412,599.67	108,411,488.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,336,000.00	7,920,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,301,625.28	14,321,124.04
210201	Тэтгэврийн даатгал	8,975,925.28	9,930,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	831,400.00	1,037,924.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	665,100.00	922,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	166,300.00	220,699.84
210205	Эрүүл мэндийн даатгал	1,662,900.00	2,209,099.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	144,204.00
210301	Гэрэл, цахилгаан	-	43,428.00
210303	Цэвэр, бохир ус	-	100,776.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,329,317.50	26,333,580.00
210401	Бичиг хэрэг	3,800,310.00	3,320,570.00
210402	Тээвэр, шатахуун	7,885,900.00	6,903,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,096,243.50	4,176,310.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,402,864.00	3,301,200.00
210408	Бараа материал акталсны зардал	-	8,488,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,500.00	2,712,700.00
210604	Урсгал засвар	4,000,500.00	2,712,700.00
2107	Томилолт, зочны зардал	6,464,200.00	1,260,500.00
210702	Дотоод албан томилолт	6,464,200.00	1,260,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,171,870.00	2,767,470.00

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,284,500.00	1,989,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	698,010.00	698,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,500.00	56,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	1,860.00	1,860.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,859,514.28	82,448,091.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,270,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,559,514.28	81,178,091.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,768,801.35	2,339,296.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,131,284.00	2,339,296.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,131,284.00	2,339,296.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(14,449,228.08)	1,432,150,155.06
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	28,815,028.88
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	28,815,028.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(28,815,028.88)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(14,449,228.08)	1,403,335,126.18

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	154,314,700.00	163,472,162.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,662,500.00	8,010,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,662,500.00	8,010,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,662,500.00	8,010,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,662,500.00	8,010,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	142,652,200.00	155,462,162.44
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	600,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	142,652,200.00	154,862,162.44
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,652,200.00	154,862,162.44
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	148,892,600.00	161,771,662.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	148,892,600.00	161,771,662.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	141,654,798.65	159,432,366.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,838,099.67	116,331,488.40
210101	Үндсэн цалин	77,382,599.67	108,411,488.40
210102	Нэмэгдэл	14,119,500.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,336,000.00	7,920,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,301,625.48	14,321,124.04
210201	Тэтгэврийн даатгал	8,975,925.48	9,930,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	831,400.00	1,037,924.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	665,100.00	922,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	166,300.00	220,699.84
210205	Эрүүл мэндийн даатгал	1,662,900.00	2,209,099.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	144,204.00
210301	Гэрэл, цахилгаан	-	43,428.00
210303	Цэвэр, бохир ус	-	100,776.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,675,103.50	19,816,880.00
210401	Бичиг хэрэг	4,378,910.00	2,809,480.00
210402	Тээвэр, шатахуун	7,992,100.00	9,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,096,243.50	3,674,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,063,850.00	3,689,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,903,900.00	4,320,700.00
210604	Урсгал засвар	4,150,000.00	4,320,700.00
2107	Томиллолт, зочны зардал	6,464,200.00	1,260,500.00
210702	Дотоод албан томиллолт	6,464,200.00	1,260,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,171,870.00	1,967,470.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,284,500.00	1,189,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	698,010.00	698,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,500.00	56,100.00

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	1,860.00	1,860.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,000.00	1,270,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,270,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,237,801.35	2,339,296.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,600,284.00	2,339,296.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,600,284.00	2,339,296.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,637,517.35	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,637,517.35	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,422,100.00</u>	<u>1,700,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>5,422,100.00</u>	<u>1,700,500.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>5,422,100.00</u>	<u>1,700,500.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	5,422,100.00	1,700,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,422,100.00	1,700,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,422,100.00)</u>	<u>(1,700,500.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,136,525.00	-	102,033,098.78		121,169,623.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,136,525.00	-	102,033,098.78	-	121,169,623.78
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(14,449,228.28)		(14,449,228.28)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,136,525.00	-	87,583,870.50	-	106,720,395.50
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	19,136,525.00	-	87,583,870.50	-	106,720,395.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,136,525.00	-	87,583,870.50	-	106,720,395.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,403,335,126.18		1,403,335,126.18
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,136,525.00	-	1,490,918,996.68	-	1,510,055,521.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	181,998,600.00	162,872,162.44	19,126,437.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	181,998,600.00	162,872,162.44	19,126,437.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	179,658,600.00	160,532,866.44	19,125,733.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	116,359,000.00	116,331,488.40	27,511.60
210101	Үндсэн цалин	108,439,000.00	108,411,488.40	27,511.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,920,000.00	7,920,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,544,900.00	14,321,124.04	223,775.96
210201	Тэтгэврийн даатгал	9,930,500.00	9,930,500.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	1,153,600.00	1,037,924.61	115,675.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	922,900.00	922,900.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	230,700.00	220,699.84	10,000.16
210205	Эрүүл мэндийн даатгал	2,307,200.00	2,209,099.59	98,100.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,740,600.00	144,204.00	6,596,396.00
210301	Гэрэл, цахилгаан	593,700.00	43,428.00	550,272.00
210303	Цэвэр, бохир ус	609,600.00	100,776.00	508,824.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,806,900.00	20,806,880.00	20.00
210401	Бичиг хэрэг	2,809,500.00	2,809,480.00	20.00
210402	Тээвэр, шатахуун	9,500,000.00	9,500,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,674,100.00	3,674,100.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,679,300.00	4,679,300.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,320,700.00	4,320,700.00	-
210604	Урсгал засвар	4,320,700.00	4,320,700.00	-
2107	Томилолт, зочны зардал	12,786,500.00	1,260,500.00	11,526,000.00
210702	Дотоод албан томилолт	12,786,500.00	1,260,500.00	11,526,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,800,000.00	2,077,970.00	722,030.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,300,000.00	1,300,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	725,000.00	698,010.00	26,990.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	56,100.00	63,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	250,000.00	1,860.00	248,140.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,000.00	1,270,000.00	30,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,270,000.00	30,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,340,000.00	2,339,296.00	704.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,340,000.00	2,339,296.00	704.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,340,000.00	2,339,296.00	704.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	181,998,600.00	162,872,162.44	19,126,437.56
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	174,998,600.00	154,862,162.44	20,136,437.56
132001	Орон нутгийн төсвөөс	174,998,600.00	154,862,162.44	20,136,437.56
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,000,000.00	8,010,000.00	(1,010,000.00)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.00	8,010,000.00	(1,010,000.00)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	8.00	9.00	(1.00)
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	6.00	1.00
620003	Үйлчлэх ажилтан		1.00	(1.00)
620004	Гэрээт ажилтан		1.00	(1.00)
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	8.00	9.00	(1.00)
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7.00	7.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	1.00	-
650010	Гэрээт ажилтан		1.00	(1.00)

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	600,000.00	(600,000.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	600,000.00	(600,000.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	600,000.00	(600,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	600,000.00	(600,000.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	600,000.00	(600,000.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	600,000.00	(600,000.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	600,000.00	(600,000.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	600,000.00	(600,000.00)

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ОНӨГ-ын дарга У.Баярбилэг танд танилцуулж байн

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлэх талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 11-нээс 2021 оны 01 дүгээр сарын 13-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Хэрлэнчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хариуцах, бүртгэлээр хяналт тавих.
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орон нутгийн өмчийн газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Орон нутгийн өмчийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт орлогын 1,479,583.0 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 14,613.79 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг өөрчлөн нийт зардлыг сонгов. Материаллаг байдлыг тооцох хувь хэмжээг 1 хувиар тооцож, 2,774.7 мянган төгрөгөөр тогтоов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орон нутгийн өмчийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,401,701.7 мянган төгрөгөөр буюу 1,313.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага		93.6	(93.6)
Урьдчилгаа			-
Бараа материал	12,748.5	11,231.4	1,517.1
Үндсэн хөрөнгө	93,971.9	1,497,097.1	(1,403,125.2)
Нийт хөрөнгө	106,720.4	1,508,422.1	(1,401,701.7)
Өр төлбөр		93.6	(93.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	106,720.4	1,508,328.5	(1,401,608.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	106,720.4	1,508,422.1	(1,401,701.7)

Авлага дансны эцсийн үлдэгдэл 93.6 мянган төгрөг болж, 93.6 мянган төгрөгөөр өссөн нь татварын хөнгөлөлтийн тооцооллыг алдаатай хийж, жилийн эцэст залруулга хийснээс шалтгаалж, татварын хэлтсээс авахаар үүссэн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 11,231.4 мянган төгрөг болж 1,517.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хагас жилийн тооллогоор ашиглалтгүй бараа материалыг холбогдох шийдвэрийн дагуу данснаас хасаж, акталснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,497,097.1 мянган төгрөг болж 1,403,125.2 мянган төгрөгөөр өссөн нь шинээр ашиглалтад орсон кино театрын барилга, түүнтэй холбогдох тавилга, тоног төхөөрөмжийг тухайн байгууллагад шилжүүлснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн хөрөнгийн худалдан авалтаар 1,700.5 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 1,513,621.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Бусад байгууллагад 28,555.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр шилжүүлж, 8,191.1 мянган төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг зохих шийдвэрийн дагуу акталж, данс бүртгэлээс хассан байна.

Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн санхүүгийн программыг орон нутгийн төсөвт байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор санхүүгийн CTS онлайн программыг биет бус хөрөнгөд 1,727.0 мянган төгрөгөөр бүртгэжээ. Харин өмчийн үйл ажиллагаанд ашиглагддаг байсан 2,200.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн программыг холбогдох шийдвэрээр бүртгэлээс хасаж, акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 93.6 мянган төгрөг болж, 93.6 мянган төгрөгөөр өссөн нь татварын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцож, албан хаагчдад олгох татвараас үүссэн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,510,055.5 мянган төгрөг болж 1,403,335.1 мянган төгрөгөөр өссөн нь шинээр баригдсан кино театрын барилга, холбогдох үндсэн хөрөнгийг хүлээн авснаас шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,417,784.4 мянган төгрөгөөр буюу 98.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй шилжүүлэн авсан үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 79,894.5 мянган төгрөгөөр буюу 47.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгө акталсны зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 206,803.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 206,803.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 24,804.8 мянган төгрөгөөр бууруулж 181,998.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 181,998.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 174,998.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 7,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 154,862.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 8,010.0 мянган төгрөг, нийт 162,872.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 162,872.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 162,872.2 мянган төгрөг буюу 89.5 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6,596.4 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардлыг 11,526.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан ба энэ нь орон

нутгийн төсвөөс олгох санхүүжилт дутуу шилжүүлсэн, мөн цар тахлын улмаас төлөвлөсөн албан томилолтын ажлууд цуцлагдсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь “үндсэн үйл ажиллагаа” арга хэмжээ 19,126.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар, гадаад төсөл хөтөлбөрөөс, Засгийн газрын нөөц сан болон Засаг даргын нөөц нөөц хөрөнгөөс, дээд шатны төсвийн захирагчаас санхүүжүүлсэн хөрөнгө бүртгэгдээгүй ба үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 600.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тендерийн урилга сонинд хэвлүүлсэн зардалд 600.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, үндсэн санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн боловч, төлөвлөгөөнөөс давсан орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих нийт 60 мэдээллээс хугацаандаа оруулсан 60 мэдээлэл байна. Хугацаа хоцроож байршуулсан болон огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тухайн байгууллагад итгэл үзүүлсэн учир аудит хийгдээгүй байна. Өмнөх жилээс шилжин ирсэн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүртгэгдээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27,901.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 15,414.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 4,402.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 8,084.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан 349.2 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалсан авсан ангилалд бүртгэж, санхүүгийн үр дүнгийн тайлан болон бараа материалын тодруулга тайланд тусгагдсан “Үнэ төлбөргүй хүлээн авсан” бараа материалын дүн зөрүүтэй тусгагдсан. Үүнийг бараа материалын тодруулга тайланд залруулав.

2. НДШ, ХХОАТ, дундын сангийн суутгалын нийт 5,550.6 мянган төгрөгийн гүйлгээг 2020 оны 1-ээс 6 дугаар саруудад цалингийн тооцооны дансанд бүртгэхгүйгээр, цалингийн зардлын данстай харьцуулан бүртгэсэн. Мөн албан хаагчдад олгосон 6,515.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг 2020 оны 1-ээс 4 дүгээр саруудад авлагын дансанд бүртгэхгүйгээр цалингийн өглөгийн дансанд бүртгэсэн. Аудитаар нийт 15,065.6 мянган төгрөгийн бичилтийн алдааг залруулав.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 8,084.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 12,486.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 4,402.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шуудан холбооны зардлаас 200.0 мянган төгрөгийг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардлаас 4,202.2 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-ын “Төсвийн шууд захирагч нь ... батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан журмын холбогдох заалттай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Үндсэн санхүүжилтийн харилцах дансанд төвлөрсөн үндсэн үйл ажиллагааны давсан орлого болох 1,010.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт дутуу олгогдсон учир зарцуулсан байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар уг асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Байгууллагын PRADO 120 маркийн автомашинд 5,792.6 мянган төгрөгийн урсгал засварыг 2020 онд хийж, 208.0 мянган төгрөгийн эд хөрөнгө автомашинд авсан байна. Автомашины урсгал засварт анхны өртгийн 13.8 хувьтай тэнцэх хэмжээний буюу 5,792.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Цаашид тухайн автомашинд зарцуулсан урсгал завсарын зардлыг тооцож байх нь зүйтэй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Жил бүр давтагдах шинжтэй 600.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан журмын 3.4.3-т “дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно:...үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах” гэж заасны дагуу үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн төлөвлөж, үндсэн санхүүжилтийн дансанд төвлөрүүлж байх.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тухайн зөрчилд шалгагдагч байгууллагаас тайлбар ирүүлээгүй болно.

2. Зардлын данстай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Аймгийн ИТХ-аар үндсэн 8 ажилтны орон тоог баталсан ба гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Тухай байгууллагад үндсэн орон тооны 8 ажилтан, гэрээт 1 ажилтан ажиллаж, батлагдсан орон тоог хэтрүүлж, орон тоо нь батлагдаагүй гэрээт ажилтанд нийт 6,048.6 мянган төгрөгийн цалин, 995.7 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт, 440.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т “Төсвийн шууд захирагч нь ...батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг зөрчсөн байна.
- 2.2. Эрсдэл: Цалингийн төсөв хүрэлцэхгүй болох.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т заасны дагуу дээд шатны байгууллагаас баталсан орон тоонд багтаан ажиллах, орон тоо нэмэх шаардлагатай тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад уламжилж, шийдвэрлүүлэх.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аймгийн Засаг даргын захирамжаар 2021 онд тус байгууллагад 1 орон тоог нэмж баталсан. Тиймээс тус зөрчил арилсан учир зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Орон нутгийн өмчийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДГА-2021/153/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Аймгийн Орон нутгийн өмчийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Давтагдах шинжтэй 600.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.	600.0	Зөвлөмж	ОНӨГ-ын дарга, нягтлан бодогч	У.Баярбилэг, А.Дэлгэрцэцэг
2	Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	4,402.2	Албан шаардлага		
3	Батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан	7,484.3	Зөвлөмж		
4	Олгосон цалингийн урьдчилгаа, суутгасан НДШ, ХХОАТ, дундын хуримтлалыг бүртгэлд буруу тусгасан	15,065.6	Аудитын явцад залруулсан		
5	Үнэ төлбөргүй авсан бараа материалыг бараа материалын тодруулга тайланд худалдан авсан ангилалд бүртгэсэн	349.2	Аудитын явцад залруулсан		
ДҮН		27,901.3			